БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГА Д.БАТЦАГААН

ШАРГА СУМЫН ХАМТЫН ХҮЧ БАГТ ҮҮРЭН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ТАВИХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1	Хийгдэх ажлын нэр	Шарга сумын Хамтын хүч багт үүрэн холбооны сүлжээ тавих
2	Байршил	Шарга сум Хамтын хүч баг
3	Захиалагч байгууллага	Шарга сумын ЗДТГазар
4	Тесөв	100,000,000
5	Зорилго	Хөдөөорон нутгийн иргэдийг үүрэн холбооны сүлжээнд бүрэн хамруулах, мэдээлэл, харилцаахолбооны хүртээмжийг сайжруулах, төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг хүртээмжтэй болгох
6	Ажлын тоо хэмжээ, тавигдах шаардлага	**1. Сүлжээний төхөөрөмж, антен, цамхаг зэргийг нийлүүлж угсрах** **2. Эрчим хүчны эх үүсвэр/нарны хавтан эсвэл генератор гэх мэт/ шийдэх** **3. Сүлжээний тохиргоо хийх, туршилт ашиглалтад хүлээлгэн өгөх** **4. Баталгаат хугацааны үйлчилгээ хийх** **ШААРДЛАГА:** • MNS стандарт болон МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа МУ-ын барилгын тухай хууль, барилгын норм ба дүрэм зэргийг баримталж, Монгол орны цаг агаарын бүсчлэл, хөрсний шинж чанар, газрын өндержилт, байгалийн тогтоц, налуулаг, салхины урсгалыг тооцож барьж гүйцэтгэсэн байх • Сүлэжжний чанар, найдвартай ажиллагааг хангах • Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой шийдэл ашиглах **5. Сайтын байр баригдах, барилгад тавигдах ерөнхий шаардлага:** a. MNS стандартууд хангасан байх b. Ажлын зурагтай байх c. Байгуулалтын ажлын холбогдох зөвшөөрөл авсан байх d. Ажлын зурагт заасан материал, тоноглолоор угсрач гүйцэтгэсэн байх e. Дадлага ажлын зураг, талбайн өдрийн тэмдэглэлтэй байх f. Батлагдсан ажлын зурагт заасны

		дагуу салхивчтай байх g. Гадна финдерийн тавиурыг оруулгаас доош 15см-д суурилуулсан байх h. Цахилгааны кабелийг сайтын байр, барилга руу оруулахдаа хамгаалах хоолойд хийн, 40см гүнд булж, тэжээлийн өрөө, шалны хэсэгт гаргаж өгсөн сувагчлалаар оруулна. i. Өрөөний хаалганы өргөн 90см-ээс багагүй байх j. Батлагдсан ажлын зурагт заасны дагуу хаалга нь саравчтай, босготой, довжоотой давхар хаалгатай байна. k. Дээвэр нь 7 градусаас багагүй налуутай байна. l. Сайтын барилга болон цамхаг хоорондын зай нь тэгш хөрсөн дээр 2м-ээс багагүй байх. m. Сайтын орчины нөхцөл 0С-с +40С байхаар барилга байгууламжийн дулаан тооцооллыг хийсэн байх n. Агааржуулалтын системтэй байх ба өвөл болон зуны цагт салхивчийг хааж, нээх боломжтой, дулаан тусгаарлалт сайтай вакум цонхтой, шавж хорхой, шороо тоос орохоос хамгаалсан сан чанрын тортой байх. **6. Цамхагт тавигдах шаардлага:** Цамхаг барихдаа тухайн газар нутгийн өндөржилт, хөрсний шинж чанар, суурилуулах төхөөрөмжийн хэмжээ, шийдлээс хамаарч, пол болон цамхагийн байгууламжийг барьж гүйцэтгэнэ. Цамхаг нь: a. MNS 5884:2020 стандартыг хангасан байна b. Ажлын зурагтай байх c. Байгууламжийн ажлын холбогдох зөвшөөрөл авсан байх d. Ажлын зурагт заасан материал, тоноглолоор угсарч гүйцэтгэсэн байх e. Далд ажлын зураг, талбайн өдрийн тэмдэглэлтэй байх f. Хөрсний дүгнэлт хийлгэсэн байх g. Цамхаг савлахаар сэргийлсэн татуургыг троссоор татсан байх h. Шат нь нурууны хамгаалалт, бүслүүртэй байх i. 20метрээс дээш цамхагийн шат нь шулуун хийцлэлтэй тохиолдолд уналтаас хамгаалах систем

		суурилуулсан байх j. Цамхагаас сайт хүртэлх кабельтрейнь хэвтээ байх k. Цамхагийн үндсэн их биеийн хэсэгт нэмэлтээр пол хийхээр бол гагнахгүй, хомутаар боож суурилуулсан байх **7. Газардуулгад тавигдах шаардлага:** a. Цамхаг MNS 5884:2020 дугаартай " Холбооны цамхаг болон барилгын суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага" стандартын 5.6 заалтыг баримтлана. b. Барилга- Сайтын барилгын газардуулга нь MNS 5146:2002-дугаартай "Хөдөлмөр аюулгүй байдал үйлдвэрлэлийн эрүүл ахуй, цахилгааны аюулгүй байдал хамгаалах газардуулга, тэлэлт" стандартын шаардлагыг хангасан байна. c. Барилга болон цамхагийн газардуулгын хүрээнүүд тусдаа хийгдэнэ. Тэдгээр нь хоорондоо холбогдсон байна. d. Сайтын газардуулгын хүрээний эсэргүүцлийн хэмжээ 4ом-с ихгүй байна. Цамхаг болон түүний орчинд байгаа харилцаа холбооны тоног төхөөрөмжүүдийг аянгаас хамгаалахын тулд ангын хүлээн авагчийн ирмэгээс хамгийн багадаа 45 градусын өнцгөөр хамгаалалтын бүс үүсгэхээр тооцож, аянга зайлуулагчийн өндрийг тодорхойлно. e. Цамхагийн оройд 12мм-ээс багагүй диаметртэй аянга зайлуулах зэс саваа байрлуулж түүнийг 10мм диаметр бүхий круг төмөрөөр цамхагаас тусгай зориулалтын изольтор ашиглан шулуун буулгаж газардуулгын хүрээнд холбоно. f. Кругийг хооронд нь холбох болон газардуулгын хүрээтэй холбохдоо ганах бөгөөд хамгийн багадаа 100мм зөрүүлсэн байна. g. Газардуулгын хүрээний гадас нь 4*4 мм, 5*5мм-тэй бэлэн төмөр байна. h. Хөрсний эсэргүүцэл болон хөрсний чанараас хамааруулан газардуулгын гадам нь 1500мм-ээс

		багагүй урттай байна. i. Цамхаг болон баригын газардуулгын хүрээнээс сайт доторх шина хүртэл 40мм өргөнтэй туузан төмөр дамжуулагчаар холбосон байна. Туузан дамжуулагчийг 0,6м –ийн гүнд суурилуулна. j. Сайтын газардуулгын шина нь зэс гулдмаа байна. **8. Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага:** a. сайтын өрөөний гэрэлтүүллэг нь 300люкс буюу түүнээс дээш байна. b. Орчин нөхцлөөс хамаараад /шат, хонгил гэх мэт/ байршилд 150 люксээс доошгүй байна.

Ажлын даалгавар боловсруулсан ХО,ОНХС-ийн ажилтан П.Бямбадулам